

# ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО

## ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Үндсэн Журмын Зорилгод заасанчлан эрүүл мэнд гэдэг нь “өвчин зовлонгүй амьдрах төдий биш” харин “бие сэтгэл, нийгмийн хувьд сайн сайхан байхыг” хэлнэ. Цаашлаад “эрүүл мэндийн хувьд хүрч болох дээд стандартад хүрэх нь үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн үзэл, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлаас үл хамааран хүн бүрийн эдлэх ёстой үндсэн эрх юм.”

Хүний эрүүл мэнд гэдгийг амьдрах эрүүл орчин, нийгмийн хүрээнд авч үзэх ёстой асуудал юм. Гринс нь эрүүл мэндийг хувь хүн болоод нийтийн эдлэх зүйл гэж үздэг бөгөөд энэ үзлийн хүрээнд хувь хүн болон цаашлаад нийгмийн эрүүл мэндийг тэтгэх журмыг боловсруулна.

## АЛСЫН ХАРАА

Гринс нь хувь хүн болоод нийгэмд бие, сэтгэл, нийгмийн сэтгэл зүйн боломжийг хамгийн дээд хэмжээнд өгөх эрүүл мэндийн систем журмыг бий болгохын төлөө ажиллана. Төрийн үйлчилгээний нэгэн адил эсэн мэнд, энх тунх амьдрах эрхийг үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн үзэл, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал байдал болон бусад дурын онцлогт тулгуурлан ялгалгүйгээр хамгаалж тэтгэх ёстой. Цаашлаад улсын болон олон улсын хөгжил дэвшлийн үзүүлэлтэд амьдрах орчин нөхцөл, эрүүл мэндийн хэмжүүрүүдийг төрийн бүх төвшний дүрэм журам, хөтөлбөр, стратегийн чиглүүр болгон оруулах шаардлагатай.

## ЗОРИЛТ

Гринсийн зорилт нь нийтийн эрүүл мэнд, эрүүл мэндийн үйлчилгээг ялгараваргүй түгээн дэлгэрүүлж хувь хүн, нийтийн эрүүл байх эрхийг тал бүрээр амьдралд нь хэрэгжүүлэх юм. Мөн хувь хүн болон нийтийн үйл хэргээр дамжуулан хувийн ашиг сонирхолын эсрэг олон нийтийн эрүүл мэндийн шинэ сэтгэлгээг гарган ирж эрүүл мэндийн нөхцөл байдлыг сайжруулахад шаардлагатай хувь хүн, нийгэм, улс төрийн өөрчлөлтүүдийг дэмжиж ажиллах юм.

## АЖЛЫН ХӨТӨЛБӨР

Гринсийн ажлын хөтөлбөр нь өвчинг эмчилж анагаахаас гадна хувь хүн, нийгмийг эрүүл мэндийн хувьд хариуцлагатай болгох эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Тус үйлчилгээ нь иргэдийг идэвхи чармайлттай болгон ардчилсан зарчмыг хөхүүлэн дэмждэг байх ба үйлчилгээг хэрэглэгчдийн өөрсдийнх нь эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөгжүүлнэ. Үүний хүрээнд Гринс нь дараах ажлуудыг гүйцэтгэнэ.

### Олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ

- Олон нийтийн санхүүжилттэй эрүүл мэндийн чанартай үйлчилгээг бүгдэд үндсэн эрхийнх нь хүрээнд хүргэх
- Олон нийтийн санхүүжилттэй шүд эрүү нүүрний анхдагч шатлалын үйлчилгээг бүгдэд хүргэхийн төлөө ажиллах
- Олон нийтийн санхүүжилттэй сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг бүгдэд хүргэх

- Эрүүл мэндийн үйлчилгээний талаар гаргах шийдвэрүүдийг хамгийн баттай нотлох баримтад үндэслэх
- Аюулгүй үр дүнтэй болох нь батлагдсан уламжлалт эрүүл мэндийн үйлчилгээ, сувилал зэргийг эрүүл мэндийн нэгдсэн үйлчилгээнд багтаах
- Эрүүл амьдрахад зайлшгүй шаардлагатай дэмжлэг туслалцаа, нөөц боломжийг эдийн засгийн бүх төвшний хүмүүст хүргэх
- Нийгмийн ялгаварлалыг арилгах урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг дэмжих
- Анхдагч шатлалтын эрүүл мэндийн үйлчилгээг урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эрт интервенц хийх, тогтмол үзлэг зэрэгт түшиглүүлэх
- Эрүүл мэндийн системийг хүний ёс, хувийн сонголт, хувийн нууц эдлэх эрхэд тулгуурлуулах
- Чандлан мөрдөгддөг, шим тэжээл, агууламжийг бүрэн дүүрэн мэдээлэхийг шаарддаг, зөвхөн шинжлэх ухаанаар батлагдсан эрүүл мэнд, шим тэжээлийн мэдэгдэл бүхий хоол хүнсний шошгололтын цогц системийг бүрдүүлэх
- Нутгийн уугуул иргэд болон бага ястнуудад соёлын хувьд зүй зохистой, олон нийтээр хянадаг эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох
- Сайн дурын дархлаажуулалтыг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга болгохыг дэмжиж ажиллах

### **Эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний мэргэжилтнүүд**

- Чанартай, хямд төсөр анагаахын үйлчилгээг бүгдэд хүртээл болгоход чиглэсэн, одоо хэрэгжиж буй арга хэмжээ, хөтөлбөр, хуулийн үйл ажиллагаануудыг дэмжих
- Анагаахын бараа үйлчилгээг боломжийн стандарт үнэтэй болгох
- Эмнэлэг, клиник болон бусад анагаахын үйлчилгээ үзүүлэгчдийг ардчилсан захиргаанд оруулах буюу эрүүл мэндийн үйлчилгээний ажилчид, хэрэглэгчид, бусад олон нийтийн ашиг сонирхолын төлөөллийг бий болгох
- Эрүүл мэндийн зардал болон эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөр зэрэг бүх төлбөр хураамж, өөрөөс гарах зардлуудыг ил тод, тодорхой мэдээллүүлэх
- Анхдагч, хоёрдогч болон эмнэлгийн шатлалын үйлчилгээг нягт уялдуулах
- Хөнгөн өвчин, гэмтлүүдийг олон нийтийн эрүүл мэндийн төвүүдэд эмчлэх
- Эмийн жор хэт бичих явдлыг багасгах
- Ажил болон замтай холбоотой осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй аргыг хэрэгжүүлж сэргээн засах эмчилгээг олгох
- Хөдөө алслагдсан орон нутгууд дахь эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн хүрэлцээг нэмэгдүүлэх
- Эрүүл мэндийн бүх ажилчдыг нөхөн төлбөрөөр хангах
- Мэргэжлийн ёс зүйгүй үйл ажиллагаа, хайхрамжгүй байдал, залилангийн эсрэг хүчтэй арга хэмжээ авах зэргээр өвчтөний аюулгүй байдлыг чухалчлах
- Олон нийтийн эрүүл мэндийн төвүүдийг өөртөө туслах, нийгэмд суурилсан санаачилга, анхдагч шатлалтын эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэндийн боловсрол, дэмжлэгийн хөтөлбөрүүдийн төв цэг болгох

- Олон нийтийн эрүүл мэндийн төвүүдэд хөнгөн гэмтэл, өвчтэй өвчтөнүүд ирж үйлчилгээ авдаг болгох

## **ХДХВ/ДОХ**

- ХДХВ/ДОХ-ын оноштой хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах
- Богино хэмжээний кино, масс медиа, нийгмийн сүлжээ болон бусад харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан ХДХВ/ДОХ-той холбоотой буруу ойлголттой тэмцэх
- Бэлгийн боловсролоор дамжуулан ХДХВ/ДОХ-ын шинэ тохиолдлуудыг бууруулах
- Ялангуяа залуучуудад ХДХВ/ДОХ-ын талаар боловсрол олгох
- ХДХВ/ДОХ-ын эсрэг тэмцлийг сэргээн иргэдийг оролцуулах
- ХДХВ/ДОХ-той хүмүүсийн амьдралыг сайжруулах

## **Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд**

- Нөхөн үржихүйн сонголтын хүрээнд хувь хүний эрх чөлөө, ёс суртахууны бие даасан байдлыг хангах
- Гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ үзүүлж үнэгүй бэлгэвч, бэлгийн эрүүл мэндийн клиник зэрэг бэлгийн эрүүл мэндийн мэдлэгийн кампанит ажлын санхүүжилтийг хангалттай олгох
- Бэлгийн боловсрол, жирэмслэлтээс хамгаалах үйлчилгээ, жендерийн эрх тэгш байдал зэргээр дамжуулан хүсээгүй жирэмслэлтийг бууруулж болохыг хүлээн зөвшөөрөх
- Жирэмслэлт, төрөлт, төрсөний дараах асаргааны үед чанартай, соёлын хувьд зүй зохистой эхийн асаргааг ДЭМБ-ийн зөвлөмжийн дагуу олгох
- Эрсдэл багатай жирэмслэлтэд байгалийн жамаар төрөх сонголтыг дэмжих
- Бүх эмэгтэйчүүд болон хүүхдийн аавуудад төрсний дараах сэтгэлийн цочрол, сэтгэл гутралыг даван гарахад дэмжлэг үзүүлэх
- Нийтийн газар, ажлын байр, дэлгүүрүүдийг эмэгтэйчүүд хүүхэд хөхүүлэхэд зориулсан газар гаргаж өгөхөд уриалах
- Эрүүл мэндийн үйлчилгээний бүх орчныг НҮБ-ын Хүүхдийн Сангийн тогтоосон хүүхдэд ээлтэй статустай болгох
- Бүх эмэгтэйчүүдэд хуулийн дагуу, үнэгүй, аюулгүй үр хөндөлтийн үйлчилгээг үзүүлэх

## **Сэтгэцийн эрүүл мэнд**

- Сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой буруу ойлголтыг бууруулах хөтөлбөр, боловсрол, мэдээллийн кампанит ажлуудыг хэрэгжүүлэх
- Сэтгэцийн болон биеийн архаг өвчтэй хүмүүсийг нийгэмтэйгээ нэгдэн, нэг хэсэг нь болж амьдрах боломжийг олгох нийгмийн дэмжлэг үйлчилгээнүүдийг хүртээмжтэй болгох
- Орон нутгийн удирдлагуудыг сэтгэцийн эрүүл мэндийн төвүүд байгуулахыг уриалах
- Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний сайн практикийн судалгаанд санхүүжилтийг хангалттай олгох
- Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээнүүдийг нас хүйс, үндэс угсаа, бэлгийн чиг хандлага, соёл, нийгэм эдийн засгийн онцлогт үндэслэн тухайн хувь хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хүргүүлэх

- Сургуулиудад хүүхдүүдийн хэлэх үгийг итгэлтэйгээр сонсох зохих бэлтгэгдсэн зөвлөгч байлгах
- Хүүхэд залуучуудын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнүүдийг зохих байдлаар санхүүжүүлж хүртээмжтэй болгох
- Орон нутгийн удирдлагуудаар амиа хорлолт ихтэй газруудад урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахуулуулах

### **Мэдээлэл авч зөвшөөрөл өгөх**

- Ямар нэг анагаах, шүд эрүү нүүр, эм зүй болон бусад ажилбарт өөрийн биеийг зориулахын өмнө хүн болгон ямар нэг дарамт шахалтгүйгээр мэдээлэл авч зөвшөөрөл өгөх эрхийг хангах. Мэдээлэл авч зөвшөөрөл өгсөн эсэхийг баталгаажуулах боломжтой байх шаардлагатай.
- Биеийн эд эрхтэн болон биед оруулж, тарьж, дээжилж, дүрсэлж авсан бүтээгдэхүүнүүдийг өвчтөний зөвшөөрөлгүйгээр ашиглаж болохгүй гэж хуульчлах
- Аливаа хувь хүний анагаах, шүд эрүү нүүр, эм зүйн бүртгэлийн мэдээллээ ямар нэг дарамт шахалтгүйгээр задруулах шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд нууцлах эрхийг нь хангах
- Өвчтөний ямарваа нэг эмчилгээ хийлгэхийг зөвшөөрөх эсвэл татгалзах сонголт хийх бүрэн эрхийг нь хамгаалах
- Өвчтөний амьдралын сүүлийн үест гаргасан анагаахын шийдвэрийг (хуулиар зөвшөөрсөн бол) нухацтай авч үзэн биелүүлж тухайн өвчтөний өөрийн анагаахын болон бусад бүртгэл мэдээллийг хүлээн авах хүнийг томилох эрхийг нь хангах
- Тухайн өвчтөн мэдээлэл авч зөвшөөрөл өгсөнийг тодорхой баримтжуулж мэдэгдэх

### **Эм болон эмийн жорны төлбөрийн хяналт зохицуулалт**

- Эмийн аюулгүй байдал, зохицуулалтыг засгийн газрын нэг агентлаг хянах
- Нийлэг эмийн бүтээгдэхүүн болон байгалийн гаралтай эмүүдэд баримт нотолгоонд үндэслэсэн үнэлгээний зохих аргыг боловсруулж мэргэжилтнүүдээр хэрэглээнийх нь талаар зөвлөмж гаргуулуулах
- Бие даасан эрүүл мэндийн үйлчилгээ эмчилгээний агентлагаар эмчилгээний үр дүн болон шинэ эмчилгээний зөвлөмжүүд дээр эрх бүхий байгууллагад баталгаа гаргуулах
- Зардлыг шаардлагатай эмчилгээ авах саад байлгахгүйн тулд эм болон жорны үнийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх
- Ариун цэврийн бүтээгдэхүүнүүдийг бусад суурь бараа таваарын адил бүх борлуулалтын татвар болон НӨАТ-аас чөлөөлөх
- Боломжтой тохиолдолд үйлчилгээ нь ижил, хямд төсөр эм хэрэглэхийг дэмжих

### **Дүүрэг, сургуулиудын эрүүл мэндийн үйлчилгээ**

- Нийгмийн үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлж эрүүл мэндийн үйлчилгээг аль болох гэрт эсвэл дүүргийн зориулалтын байран дээр үзүүлэх боломжийг бүрдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, бие сэтгэцийн асуудалтай хүмүүсийн нийгмийн үйлчилгээг нэмэгдүүлэх

- Шинэ, эрүүл, орон нутгаас авсан өдрийн хоол сурагчдад өгөх санхүүжилт чадамжийг сургууль бүрт олгох
- Сургуулийн хичээлийн хөтөлбөрт биеийн тамирын хичээлийг оруулж сургуулийн дараа сурагчид хамрагдаж болох хөтөлбөрүүдийг нэвтрүүлэх
- Улсын хэмжээнд мансууруулах бодисын хэрэглээг бууруулах бодлогыг боловсруулж илүү аюулгүй тариа хийх газруудыг байгуулах
- Эрүүл мэнд болон эрүүл мэндийн асуудлын талаарх боловсролын хөтөлбөрүүдийг сургууль болон ажлын байран дээр боловсруулах

### **Судалгаа, хөгжүүлэлт**

- Хямд төсөр эмнэлгийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэлтийн цогц хөтөлбөр, эмийн бүтээгдэхүүн, эмчилгээ заслын бараа, эмнэлгийн төхөөрөмж болон бусад эрүүл мэндийн засал, технологиудын үнэлгээ, зөвшөөрөл, зохицуулалт, маркетингийн нарийн системийг хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн үйлчилгээ, ялангуяа олон нийтийн эрүүл мэнд, тархвар судлал, сувилал, нийгмийн эрүүл мэнд, анхдагч шатлалын асаргаанд хийгдэх судалгаа шинжилгээний ажлыг дэмжих
- Орчин үеийн болон уламжлалт анагаахын судалгааны санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх

### **Бусад**

- Байгаль орчин, эрүүл мэндэд ээлтэй аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих
- Пестицид, гликол, мөнгөн ус, үйлдвэрийн химийн бодис зэрэг эрүүл мэндэд аюултай хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүдийг хориглох, хянах
- Эмийн замбараагүй хэрэглээ, донтолтоос урьдчилан сэргийлэх, хянахын тулд эмч нарын бичсэн эмийн жоронд хяналт тавих
- Ажлын байран дээр хөдөлмөрийн эрүүл мэндийн зохих үйлчилгээ үзүүлдэг байх
- ЛГБТИКА болон нийгэмд зориулсан эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлж эрсдэлд орох магадлалтай хүмүүсийг тогтоож дэмжих
- Хүний бэлгийн чиг хандлага, жендерийн чиг хандлагыг хүчээр өөрчлөх зорилготой бүх төрлийн эмчилгээг сурталчлах, санхүүжүүлэх, хийхийг хориглох
- Сахарын агууламж өндөртэй хоол ундны хэрэглээг багасгах

### **Ашигласан материал:**

<https://www.who.int/about/who-we-are/constitution>

<https://www.un.org/en/sections/issues-depth/health/index.html>

<https://www.globalgreens.org/globalcharter-english>

<https://greens.org.au/policies/health>

[https://www.greens.org.nz/health\\_policy](https://www.greens.org.nz/health_policy)

<https://www.cagreens.org/platform/health-care>

<https://policy.greenparty.org.uk/he.html>

<https://indiagreensparty.org/policies/health/>

<https://www.greenparty.ca/en/our-vision/health-care>

<https://www.who.int/reproductivehealth/publications/intrapartum-care-guidelines/en/>